

САММИТМЕДИКАЛ СЕРВИС ХХК-д

Тендерийн талаар тодруулга хариу өгөх тухай

2024.05.13

Улсын нэгдүгээр төв эмнэлгээс зарласан СТ, MRI, Ангиографи аппаратын баталгаат засвар, хэт авиан аппаратын сэлбэг худалдан авах УНТЭ/20240101010/01/04 тоот тендерт оролцоо бэлтгэж буй Саммитмедикал Сервис ХХК-ын хүсэлтээр дараах тенперийн заалтад хариу өгч байна. Тус заалт нь:

- Багц З Компьютер томографийн ажлын жагсаалтад: “Рентген хоолой 2015 оноос аппарат ашиглаж эхэлснээс хойш тасралтгүй ажиллаж байгаа бөгөөд ашиглалтын хугацаанаас шалтгаалан зургийн чанар муудсан тул баталгаат засвар үйлчилгээний гэрээний хугацаанд рентген хоолойг солиулах” гэж оруулсан.

Philips Ingenuity 128 СТ аппарат нь 2015 оны 8 сард ашиглалтанд орж одоог хүртэл 9 жилийн хугацаанд тасралтгүй ачаалал ихтэй ажиллаж байна. СТ аппаратны зургийн чанар муудаж, толгойны зураг авах боломжгүй болж зөвхөн нурууны зураг авч байгаа бөгөөд өмнөх баталгаат засварын хугацаанд манай байгууллагаас удаа дараа зургийн чанар муудсан талаар дуудлага өгч, тохиргоо үйлчилгээ хийлгэсэн боловч хэвийн ажиллагаанд ороогүй болно. Зургийн чанар муудаж нягтаршилтай зураг авч чадахгүй байгаа нь рентген хоолойноос шалтгаалсан гэж үзэж байгаа тул “Багц З”-д заасан техникийн тодорхойлолтыг өөрчлөх боломжгүй байна. Хамтран ажиллаж байгаа та бүхэнд баярлалаа.

Хянасан: Техникийн албаны дарга

С.Учрал

Тодруулга гаргасан: Техникийн албаны инженер Л.Бямбадорж Л.Бямбадорж

Техникийн албаны инженер Г.Өлзийжаргал Г.Өлзийжаргал